



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДГА-2026/96/НА-СТА-ТШЗ

|   |  |
|---|--|
| Цахим хуудас:<br><a href="http://www.audit.mn">www.audit.mn</a><br>Дорноговь аймаг<br>2026 он | Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий<br>Утас: 70522734<br>Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn<br>Аудитын менежер: У.Оюунтүлхүүр<br>Утас: 70523020<br>Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn<br>Аудитор: Н.Мөнхнасан<br>Цахим хаяг: munkhnasann@audit.gov.mn |
|---|--|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,  
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,  
Утас: (976) 7052 2734

Цахим хуудас: [dornogovi@audit.gov.mn](mailto:dornogovi@audit.gov.mn)

2023.02.23 № 1-6/79

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ЭРДЭНЭ СУМЫН ЗАСАГ  
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГА Г.АЛТАНЦАЦРАЛ ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайлант онд уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа ХХК-тай нийгмийн хариуцлагын хүрээнд байгуулсан гэрээний дагуу ОНХС-д төвлөрүүлэх 17,800.0 мянган төгрөгийн мөнгөн хандивыг нэмэлт санхүүжилтийн харилцах дансанд авч зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2-т “Хуульд өөрөөр заагаагүй бол зөвхөн эмнэлгийн үйлчилгээ, бүх шатны боловсролын үйлчилгээ, соёлын үйлчилгээ, хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэх зэрэг нийгмийн үйлчилгээ үзүүлдэг төсвийн байгууллага энэ хуульд заасан журмын дагуу хандив, тусламж авч болно”, 60 дугаар зүйлийн 60.2.9-д “Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэр нь ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан гэрээний дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нутгийн захиргааны байгууллагад өгсөн хандив тусламжаас бүрдэнэ” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Нийт илрүүлсэн 20,851.9 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 12,465.9 мянган төгрөгөөр давсан тул хязгаарлалттай дүгнэлт өгөх үндэслэл болов.

### Асуудлыг онцолсон хэсэг

Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн 3,051.8 мянган төгрөгийг, үндсэн цалингаас шилжүүлж эдийн засгийн ангилал зөрчиж, зориулалт бусаар зарцуулсан

442505042

байна. Өмнөх онд гарсан зөрчлийг тайлант онд тус зөрчил давтагдсан тул таслан зогсоох албан шаардлага өгөхөөр шийдвэрлэсэн.

#### **Аудитын гол асуудал**

Эд хөрөнгийн тооллогыг албан хаагчдаар түүвэрлэн тоолж, тулгалт хийхэд хэрэглэж байгаа хөрөнгөд хөрөнгө бүртгэлийн наалт болон ашиглалтын бүртгэлгүй, тухайн албан хаагчийн хэрэглэж байгаа хөрөнгө мөн гэхийг нотлох боломжгүй байгаа бөгөөд, байгууллагын хагас жилийн тооллогыг албан хаагч бүрээр тулгаж тоолсон гэх нотолгоо хангалтгүй байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд бусад асуудлын хэсэгт дурьдах асуудал илрээгүй болно.

АДБОУС 2706.10-д зааснаар хууль тогтоомжоор хориглоогүй, аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй, тухайлбал аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт   | Эхний үлдэгдэл          | Эцсийн үлдэгдэл         |
|------------|---|-------------------------|-------------------------|
| 1          | <b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>  | <b>332,660,641.48</b>   | <b>414,958,180.35</b>   |
| 31         | <b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>   | <b>9,810,329.28</b>     | <b>18,500,329.28</b>    |
| 312        | <b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>                                     | <b>9,810,329.28</b>     | <b>18,500,329.28</b>    |
| 3121       | <b>Төгрөг</b>   | <b>9,810,329.28</b>     | <b>18,500,329.28</b>    |
| 31211      | Төрийн сангийн харилцах   | 9,810,329.28            | 18,500,329.28           |
| 33         | <b>АВЛАГА</b>   | <b>16,019,555.24</b>    | <b>42,092,394.11</b>    |
| 33100      | Ажиллагчидтай холбогдсон авлага                                       | 332,756.24              | 1,125,385.11            |
| 335        | <b>Бусад авлага</b>   | <b>15,686,799.00</b>    | <b>40,967,009.00</b>    |
| 3351       | Байгууллагаас авах авлага   | 15,686,799.00           | 38,117,009.00           |
| 3352       | Хувь хүмүүсээс авах авлага  | -                       | 2,850,000.00            |
| 35         | <b>БАРАА МАТЕРИАЛ</b>   | <b>202,579,256.96</b>   | <b>265,507,956.96</b>   |
| 351        | <b>Түүхий эд материал</b>   | <b>46,622,665.00</b>    | <b>46,622,665.00</b>    |
| 35110      | Тусгай зориулалттай материал  | 46,622,665.00           | 46,622,665.00           |
| 354        | <b>Хангамжийн материал</b>  | <b>155,956,591.96</b>   | <b>218,885,291.96</b>   |
| 35410      | Бичиг хэргийн материал  | 1,079,796.50            | 1,451,096.50            |
| 35420      | Аж ахуйн материал   | 11,448,000.00           | 11,364,000.00           |
| 35430      | Сэлбэг хэрэгсэл   | 2,844,320.00            | 2,265,320.00            |
| 35440      | Түлш, шатах тослох материал   | 14,000.00               | 14,000.00               |
| 35470      | Бусад хангамжийн материал   | 140,570,475.46          | 203,790,875.46          |
| 36         | <b>НӨӨЦИЙН БАРАА</b>  | <b>104,251,500.00</b>   | <b>88,857,500.00</b>    |
| 36300      | Тэжээлийн нөөц  | 104,251,500.00          | 88,857,500.00           |
| 2          | <b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>                                    | <b>2,546,026,251.95</b> | <b>2,957,278,420.31</b> |
| 39         | <b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>   | <b>2,546,026,251.95</b> | <b>2,957,278,420.31</b> |
| 392        | <b>Биет хөрөнгө</b>   | <b>2,456,276,851.95</b> | <b>2,868,086,720.31</b> |
| 39201      | Барилга, байгууламж, орон сууц  | 1,133,822,659.00        | 1,690,806,883.00        |
| 39202      | Хуримтлагдсан элэгдэл   | (178,365,886.74)        | (277,885,753.07)        |
| 39203      | Авто-тээврийн хэрэгсэл  | 361,620,000.00          | 328,960,000.00          |
| 39204      | Хуримтлагдсан элэгдэл   | (180,636,889.05)        | (191,055,778.11)        |
| 39205      | Машин тоног төхөөрөмж (компьютер)                                     | 148,620,201.11          | 202,357,911.04          |
| 39206      | Хуримтлагдсан элэгдэл   | (66,565,934.23)         | (82,642,448.73)         |
| 39207      | Тавилга, аж ахуйн эд хогшил   | 76,054,582.03           | 70,458,670.03           |
| 39208      | Хуримтлагдсан элэгдэл   | (17,719,647.29)         | (22,487,390.47)         |
| 39214      | Бусад үндсэн хөрөнгө  | 1,541,233,157.33        | 1,609,773,017.33        |
| 39215      | Хуримтлагдсан элэгдэл   | (362,674,850.21)        | (461,087,850.71)        |
| 39217      | Ном   | 889,460.00              | 889,460.00              |
| 393        | <b>Биет бус хөрөнгө</b>   | <b>89,749,400.00</b>    | <b>89,191,700.00</b>    |
| 39301      | Програм хангамж   | 1,115,400.00            | 1,115,400.00            |
| 39302      | Хуримтлагдсан элэгдэл   | -                       | (557,700.00)            |
| 39303      | Бусад биет бус хөрөнгө  | 88,634,000.00           | 88,634,000.00           |
| 3          | <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>                                    | <b>2,878,686,893.43</b> | <b>3,372,236,600.66</b> |
| 4          | <b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>   | <b>16,545,239.70</b>    | <b>570,498.04</b>       |
| 41         | <b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>                                      | <b>16,545,239.70</b>    | <b>570,498.04</b>       |
| 413        | <b>Өглөг</b>  | <b>16,545,239.70</b>    | <b>570,498.04</b>       |
| 41310      | Ажилчидтай холбогдсон өглөг   | 16,545,239.20           | -                       |
| 4136       | <b>Бусад өглөг</b>  | <b>0.50</b>             | <b>570,498.04</b>       |
| 41361      | Байгууллагад төлөх өглөг  | 0.50                    | 570,498.04              |
| 5          | <b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>                                       | <b>2,862,141,653.73</b> | <b>3,371,666,102.62</b> |
| 51         | <b>Засгийн газрын хувь оролцоо</b>                                    | <b>2,862,141,653.73</b> | <b>3,371,666,102.62</b> |
| 511        | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 528,431,611.57          | 528,431,611.57          |
| 512        | <b>Хуримтлагдсан үр дүн</b>   | <b>2,114,507,807.32</b> | <b>2,624,032,256.21</b> |
| 51210      | Өмнөх үеийн үр дүн  | 2,114,507,807.32        | 2,127,121,131.17        |
| 51220      | Тайлант үеийн үр дүн  | -                       | 496,911,125.04          |
| 51300      | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү                                      | 219,202,234.84          | 219,202,234.84          |

|   |  |                         |                         |
|---|--|-------------------------|-------------------------|
| 6 | <b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b> | <b>2,878,686,893.43</b> | <b>3,372,236,600.66</b> |
|---|--|-------------------------|-------------------------|

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт   | Өмнөх оны гүйцэтгэл     | Тайлант оны гүйцэтгэл   |
|------------|--|-------------------------|-------------------------|
| 1          | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>   | <b>1,508,837,934.25</b> | <b>2,228,275,225.43</b> |
| 12         | <b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>   | <b>171,950,980.00</b>   | <b>795,677,632.93</b>   |
| 120        | <b>Нийтлэг татварын бус орлого</b>   | 171,950,980.00          | 795,677,632.93          |
| 120004     | Төсөв байгууллагын өөрийн орлого   | 171,950,980.00          | 795,677,632.93          |
| 1200042    | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих  | 1,000,000.00            | 3,850,000.00            |
| 1200017    | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /үндсэн хөрөнгө/   | 170,950,980.00          | 791,042,632.93          |
| 1200018    | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /бараа материал/   |                         | 785,000.00              |
| 13         | <b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>   | <b>1,336,886,954.25</b> | <b>1,432,597,592.50</b> |
| 1311       | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>   | <b>180,128,995.00</b>   | <b>238,936,592.50</b>   |
| 131104     | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 121,925,000.00          | 165,615,305.00          |
| 131105     | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого                               | 58,203,995.00           | 73,321,287.50           |
| 1320       | <b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>  | <b>1,156,757,959.25</b> | <b>1,193,661,000.00</b> |
| 132001     | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/  | 1,156,757,959.25        | 1,193,661,000.00        |
| 2          | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>   | <b>1,506,222,063.53</b> | <b>1,717,048,628.24</b> |
| 21         | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>   | <b>1,506,222,063.53</b> | <b>1,717,048,628.24</b> |
| 210        | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>   | <b>1,498,935,063.53</b> | <b>1,688,759,521.42</b> |
| 2101       | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>   | <b>775,682,889.92</b>   | <b>852,168,147.85</b>   |
| 210101     | Үндсэн цалин   | 431,882,119.08          | 407,552,205.32          |
| 210102     | Нэмэгдэл   | 237,550,336.80          | 291,550,691.00          |
| 210103     | Унаа хоолны хөнгөлөлт  | 54,219,998.35           | 76,479,988.72           |
| 210104     | Урамшуулал   | 43,570,440.00           | 47,982,485.81           |
| 210105     | Гэрээт ажлын хөлс  | 8,459,995.69            | 28,602,777.00           |
| 2102       | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>  | <b>92,405,365.73</b>    | <b>97,465,850.25</b>    |
| 210201     | Тэтгэврийн даатгал   | 63,742,624.79           | 64,064,973.63           |
| 210202     | Тэтгэмжийн даатгал   | 7,438,400.00            | 8,122,800.00            |
| 210203     | ҮОМШӨ-ний даатгал  | 5,950,700.00            | 4,036,297.98            |
| 210204     | Ажилгүйдлийн даатгал   | 1,487,700.00            | 4,369,356.24            |
| 210205     | Эрүүл мэндийн даатгал  | 13,785,940.94           | 16,872,422.40           |
| 2103       | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>   | <b>74,477,900.00</b>    | <b>98,647,487.86</b>    |
| 210301     | Гэрэл, цахилгаан   | 18,231,900.00           | 18,820,019.86           |
| 210302     | Түлш, халаалт  | 51,506,700.00           | 73,335,995.00           |
| 210303     | Цэвэр, бохир ус  | 4,739,300.00            | 6,491,473.00            |
| 2104       | <b>Хангамж, бараа материалын зардал</b>  | <b>58,461,694.87</b>    | <b>20,393,073.00</b>    |
| 210401     | Бичиг хэрэг  | 6,190,660.00            | 2,137,400.00            |
| 210402     | Тээвэр, шатахуун   | 46,742,254.87           | 15,799,450.00           |
| 210403     | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр   | 2,660,230.00            | 1,152,323.00            |
| 210405     | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал  | 240,000.00              | -                       |
| 210406     | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс  | 2,613,550.00            | 1,303,900.00            |
| 210407     | Аж ахуйн материал худалдан авах зардал   | 15,000.00               | -                       |
| 2106       | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>   | <b>23,872,020.00</b>    | <b>5,384,300.00</b>     |
| 210604     | Урсгал засвар  | 23,872,020.00           | 5,384,300.00            |
| 2107       | <b>Томилолт, зочны зардал</b>  | <b>6,920,100.00</b>     | <b>3,580,400.00</b>     |
| 210702     | Дотоод албан томилолт  | 6,920,100.00            | 3,580,400.00            |

|        |  |                       |                       |
|--------|--|-----------------------|-----------------------|
| 2108   | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>      | <b>234,094,874.00</b> | <b>234,625,270.04</b> |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 233,077,540.00        | 233,895,830.04        |
| 210803 | Даатгалын үйлчилгээ  | 543,150.00            | 586,440.00            |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар   | 298,368.00            | -                     |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо  | 121,000.00            | 143,000.00            |
| 210807 | Газрын төлбөр  | 54,816.00             | -                     |
| 2109   | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                               | <b>233,020,219.01</b> | <b>376,494,992.42</b> |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал                                      | 5,500,000.00          | 5,000,000.00          |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                                    | 220,000.00            | 1,020,000.00          |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол                                   | 227,300,219.01        | 370,474,992.42        |
| 213    | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>  | <b>7,287,000.00</b>   | <b>28,289,106.82</b>  |
| 2132   | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>  | <b>7,287,000.00</b>   | <b>15,300,000.00</b>  |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                              | 7,287,000.00          | 15,300,000.00         |
| 2133   | <b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>                   | -                     | 12,989,106.82         |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг  | -                     | 12,989,106.82         |
| 3      | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>                            | <b>2,615,870.72</b>   | <b>511,226,597.19</b> |
| 225    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>                               | 788,074.27            | -                     |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз                                       | 788,074.27            | -                     |
| 225010 | Үнэ төлбөргүй гарсан зардал /үндсэн хөрөнгө/                         |                       | 14,315,472.15         |
| 4      | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>                      | (788,074.27)          | (14,315,472.15)       |
| 5      | <b>НИИТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>                                       | <b>1,827,796.45</b>   | <b>496,911,125.04</b> |

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт   | Өмнөх оны гүйцэтгэл     | Тайлант оны гүйцэтгэл   |
|------------|--|-------------------------|-------------------------|
|            | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>  |                         |                         |
| 1          | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>  | <b>1,348,154,702.53</b> | <b>1,466,284,391.50</b> |
| 12         | <b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>   | <b>4,916,349.28</b>     | <b>18,000,000.00</b>    |
| 120        | Нийтлэг татварын бус орлого  | 4,916,349.28            | 18,000,000.00           |
| 120004     | Төсөв байгууллагын өөрийн орлого   | 1,000,000.00            | 1,000,000.00            |
| 1200042    | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих  | 1,000,000.00            | 1,000,000.00            |
| 120009     | Бусад орлого   | 3,916,349.28            | 17,000,000.00           |
| 13         | <b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>   | <b>1,343,238,353.25</b> | <b>1,448,284,391.50</b> |
| 1311       | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>   | 186,480,394.00          | 254,623,391.50          |
| 131104     | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 121,925,000.00          | 165,615,305.00          |
| 131105     | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого                               | 64,555,394.00           | 89,008,086.50           |
| 1320       | <b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>  | 1,156,757,959.25        | 1,193,661,000.00        |
| 132001     | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/  | 1,156,757,959.25        | 1,193,661,000.00        |
| 2          | <b>НИИТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>   | <b>1,323,351,554.25</b> | <b>1,452,594,391.50</b> |
| 21         | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>   | <b>1,323,351,554.25</b> | <b>1,452,594,391.50</b> |
| 210        | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>   | <b>1,315,641,554.25</b> | <b>1,386,188,275.68</b> |
| 2101       | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>   | <b>763,054,000.00</b>   | <b>869,106,305.32</b>   |
| 210101     | Үндсэн цалин   | 343,533,813.11          | 431,899,500.69          |
| 210102     | Нэмэгдэл   | 294,949,439.41          | 287,720,500.00          |
| 210103     | Унаа хоолны хөнгөлөлт  | 55,190,047.48           | 76,479,988.72           |

|        |  |                       |                       |
|--------|--|-----------------------|-----------------------|
| 210104 | Урамшуулал   | 49,420,700.00         | 44,494,315.91         |
| 210105 | Гэрээт ажлын хөлс  | 19,960,000.00         | 28,512,000.00         |
| 2102   | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>                | <b>92,738,115.75</b>  | <b>99,556,237.00</b>  |
| 210201 | Тэтгэврийн даатгал   | 62,984,615.75         | 67,116,837.00         |
| 210202 | Тэтгэмжийн даатгал   | 7,438,400.00          | 8,122,800.00          |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал  | 5,950,700.00          | 4,036,600.00          |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал   | 1,487,700.00          | 4,036,600.00          |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал  | 14,876,700.00         | 16,243,400.00         |
| 2103   | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>                     | <b>74,477,900.00</b>  | <b>98,647,487.86</b>  |
| 210301 | Гэрэл, цахилгаан   | 18,231,900.00         | 18,820,019.86         |
| 210302 | Түлш, халаалт  | 51,506,700.00         | 73,335,995.00         |
| 210303 | Цэвэр, бохир ус  | 4,739,300.00          | 6,491,473.00          |
| 2104   | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                              | <b>48,358,979.50</b>  | <b>18,031,225.50</b>  |
| 210401 | Бичиг хэрэг  | 7,370,000.00          | 1,415,700.00          |
| 210402 | Тээвэр, шатахуун   | 36,288,749.50         | 14,281,802.50         |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр                                   | 2,660,230.00          | 1,152,323.00          |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал            | 240,000.00            | -                     |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс                          | 1,800,000.00          | 1,181,400.00          |
| 2106   | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                             | <b>25,999,990.00</b>  | <b>5,461,800.00</b>   |
| 210604 | Урсгал засвар  | 25,999,990.00         | 5,461,800.00          |
| 2107   | <b>Томилолт, зочны зардал</b>  | <b>6,920,100.00</b>   | <b>3,340,800.00</b>   |
| 210702 | Дотоод албан томилолт  | 6,920,100.00          | 3,340,800.00          |
| 2108   | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>      | <b>295,792,469.00</b> | <b>285,756,920.00</b> |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 294,775,135.00        | 285,027,480.00        |
| 210803 | Даатгалын үйлчилгээ  | 543,150.00            | 586,440.00            |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар   | 298,368.00            | -                     |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо  | 121,000.00            | 143,000.00            |
| 210807 | Газрын төлбөр  | 54,816.00             | -                     |
| 2109   | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                               | <b>8,300,000.00</b>   | <b>6,287,500.00</b>   |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал                                      | 5,500,000.00          | 5,000,000.00          |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                                    | 2,800,000.00          | 1,287,500.00          |
| 213    | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>  | <b>7,710,000.00</b>   | <b>66,406,115.82</b>  |
| 2132   | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>  | <b>7,710,000.00</b>   | <b>15,300,000.00</b>  |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                              | 7,710,000.00          | 15,300,000.00         |
| 2133   | <b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>                   | -                     | 51,106,115.82         |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг  | -                     | 12,989,106.82         |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутаг/                                   |                       | 38,117,009.00         |
| 3      | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>              | <b>24,803,148.28</b>  | <b>13,690,000.00</b>  |
| 5      | <b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>                     | <b>10,800,000.00</b>  | <b>5,000,000.00</b>   |
| 22     | <b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>  | <b>10,800,000.00</b>  | <b>5,000,000.00</b>   |
| 2200   | <b>Дотоод эх үүсвэрээр</b>   | <b>10,800,000.00</b>  | <b>5,000,000.00</b>   |

|        |  |                              |                             |
|--------|--|------------------------------|-----------------------------|
| 222001 | Тоног төхөөрөмж  | 5,800,000.00                 | 5,000,000.00                |
| 223001 | Бусад хөрөнгө  | 5,000,000.00                 | -                           |
| 6      | <b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b> | <b><u>-10,800,000.00</u></b> | <b><u>-5,000,000.00</u></b> |
| 8      | <b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>                           | 14,003,148.28                | 8,690,000.00                |
| 9      | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл                           |                              | 9,810,329.28                |
| 10     | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл                          | 9,810,329.28                 | 18,500,329.28               |

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт                                   | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|-----|--|---------------------------------|-----------------------|-------------------|--|
| 1   | 2024 оны 12-р сарын 31-нээх үлдэгдэл       | 528,431,611.57                  | 219,202,234.84        | 2,114,507,807.32  | 2,862,141,653.73                       |
| 2   | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | -                               | -                     | -                 | -                                      |
| 3   | Дахин илэрхийлсэн үлдэгдэл                 | 528,431,611.57                  | 219,202,234.84        | 2,114,507,807.32  | 2,862,141,653.73                       |
| 8   | 2024 оны 12-р сарын 31-нээх үлдэгдэл       | 528,431,611.57                  | 219,202,234.84        | 2,114,507,807.32  | 2,862,141,653.73                       |
| 9   | 2025 оны 1-р сарын 1-нээх үлдэгдэл         | 528,431,611.57                  | 219,202,234.84        | 2,114,507,807.32  | 2,862,141,653.73                       |
| 10  | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | -                               | -                     | 12,613,323.85     | 12,613,323.85                          |
| 11  | Дахин илэрхийлсэн үлдэгдэл                 | 528,431,611.57                  | 219,202,234.84        | 2,127,121,131.17  | 2,874,754,977.58                       |
| 16  | Тайлант үеийн үр дүн                       | -                               | -                     | 496,911,125.04    | 496,911,125.04                         |
| 17  | 2025 оны 12-р сарын 31-нээх үлдэгдэл       | 528,431,611.57                  | 219,202,234.84        | 2,624,032,256.21  | 3,371,666,102.62                       |

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт   | Тайлант оны           |                  |               |
|------------|--|-----------------------|------------------|---------------|
|            |  | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл        | Зөрүү         |
| 1          | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл |                       |                  |               |
| 2          | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН                | 1,198,000,300.00      | 1,181,671,893.18 | 16,328,406.82 |
| 21         | УРСГАЛ ЗАРДАЛ                                    | 1,198,000,300.00      | 1,181,671,893.18 | 16,328,406.82 |
| 210        | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                  | 1,197,600,300.00      | 1,181,671,893.18 | 15,928,406.82 |

|        |  |                  |                  |                 |
|--------|--|------------------|------------------|-----------------|
| 2101   | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>                             | 872,576,400.00   | 869,106,305.32   | 3,470,094.68    |
| 210101 | Үндсэн цалин   | 440,583,800.00   | 431,899,500.69   | 8,684,299.31    |
| 210102 | Нэмэгдэл   | 301,720,500.00   | 287,720,500.00   | 14,000,000.00   |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт  | 61,920,000.00    | 76,479,988.72    | (14,559,988.72) |
| 210104 | Урамшуулал   | 39,840,100.00    | 44,494,315.91    | (4,654,215.91)  |
| 210105 | Гэрээт ажлын хөлс  | 28,512,000.00    | 28,512,000.00    | -               |
| 2102   | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>                | 105,055,600.00   | 99,556,237.00    | 5,499,363.00    |
| 210201 | Тэтгэврийн даатгал   | 69,929,000.00    | 67,116,837.00    | 2,812,163.00    |
| 210202 | Тэтгэмжийн даатгал   | 8,781,600.00     | 8,122,800.00     | 658,800.00      |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал  | 4,390,900.00     | 4,036,600.00     | 354,300.00      |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал   | 4,390,900.00     | 4,036,600.00     | 354,300.00      |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал  | 17,563,200.00    | 16,243,400.00    | 1,319,800.00    |
| 2103   | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>                     | 99,352,800.00    | 98,647,487.86    | 705,312.14      |
| 210301 | Гэрэл, цахилгаан   | 18,703,800.00    | 18,820,019.86    | (116,219.86)    |
| 210302 | Түлш, халаалт  | 75,374,900.00    | 73,335,995.00    | 2,038,905.00    |
| 210303 | Цэвэр, бохир ус  | 5,274,100.00     | 6,491,473.00     | (1,217,373.00)  |
| 2104   | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                              | 12,935,900.00    | 11,617,323.00    | 1,318,577.00    |
| 210401 | Бичиг хэрэг  | 1,659,000.00     | 1,415,700.00     | 243,300.00      |
| 210402 | Тээвэр, шатахуун   | 8,742,900.00     | 8,742,900.00     | -               |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр                                   | 1,164,000.00     | 1,152,323.00     | 11,677.00       |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал            | 140,000.00       | -                | 140,000.00      |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс                          | 1,230,000.00     | 306,400.00       | 923,600.00      |
| 2106   | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                             | 11,500,000.00    | 10,461,800.00    | 1,038,200.00    |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл  | 6,000,000.00     | 5,000,000.00     | 1,000,000.00    |
| 210604 | Урсгал засвар  | 5,500,000.00     | 5,461,800.00     | 38,200.00       |
| 2107   | <b>Томилолт, зочны зардал</b>  | 3,341,200.00     | 3,340,800.00     | 400.00          |
| 210702 | Дотоод албан томилолт  | 3,341,200.00     | 3,340,800.00     | 400.00          |
| 2108   | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>      | 86,188,400.00    | 82,654,440.00    | 3,533,960.00    |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 84,995,400.00    | 81,925,000.00    | 3,070,400.00    |
| 210803 | Даатгалын үйлчилгээ  | 850,000.00       | 586,440.00       | 263,560.00      |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо  | 143,000.00       | 143,000.00       | -               |
| 210807 | Газрын төлбөр  | 200,000.00       | -                | 200,000.00      |
| 2109   | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                               | 6,650,000.00     | 6,287,500.00     | 362,500.00      |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал                                      | 5,250,000.00     | 5,000,000.00     | 250,000.00      |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                                    | 1,400,000.00     | 1,287,500.00     | 112,500.00      |
|        | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                                | 1,199,000,300.00 | 1,194,661,000.00 | 4,339,300.00    |
| 1320   | <b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                                | 1,198,000,300.00 | 1,193,661,000.00 | 4,339,300.00    |
| 132001 | Орон нутгийн төсвөөс   | 1,198,000,300.00 | 1,193,661,000.00 | 4,339,300.00    |

|         |  |              |              |   |
|---------|--|--------------|--------------|---|
| 120004  | <b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b> | 1,000,000.00 | 1,000,000.00 | - |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих    | 1,000,000.00 | 1,000,000.00 | - |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт   | Гүйцэтгэл             | Зөрүү                   |
|------------|--|-----------------------|-------------------------|
| <b>I</b>   | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>   | <b>194,516,382.50</b> | <b>(194,516,382.50)</b> |
| 21         | УРСГАЛ ЗАРДАЛ  | 194,516,382.50        | (194,516,382.50)        |
| 210        | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ  | 194,516,382.50        | (194,516,382.50)        |
| 2104       | Хангамж, бараа материалын зардал   | 6,413,902.50          | (6,413,902.50)          |
| 210402     | Тээвэр, шатахуун   | 5,538,902.50          | (5,538,902.50)          |
| 210406     | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс  | 875,000.00            | (875,000.00)            |
| 2108       | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>  | <b>188,102,480.00</b> | <b>(188,102,480.00)</b> |
| 210801     | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж                                       | 188,102,480.00        | (188,102,480.00)        |
| <b>II</b>  | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>  | <b>232,633,391.50</b> | <b>(232,633,391.50)</b> |
| 1311       | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>   | <b>232,633,391.50</b> | <b>(232,633,391.50)</b> |
| 131104     | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 165,615,305.00        | (165,615,305.00)        |
| 131105     | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого                               | 67,018,086.50         | (67,018,086.50)         |

## 2.7 Аудит хийсэн ахмадын сангийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Код    | Үзүүлэлт   | Төсвийн тохируулга   | зөрүү                  |
|--------|--|----------------------|------------------------|
| 1      | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>            | <b>23,990,000.00</b> | <b>(23,990,000.00)</b> |
| 12     | <b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>                               | <b>23,990,000.00</b> | <b>(23,990,000.00)</b> |
| 120    | <b>Нийтлэг татварын бус орлого</b>                       | <b>23,990,000.00</b> | <b>(23,990,000.00)</b> |
| 120004 | <b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>                  | <b>6,990,000.00</b>  | <b>(6,990,000.00)</b>  |
| 120009 | <b>Бусад орлого</b>                                      | <b>17,000,000.00</b> | <b>(17,000,000.00)</b> |
| 2      | <b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>                 | <b>15,300,000.00</b> | <b>(15,300,000.00)</b> |
| 21     | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                                     | <b>15,300,000.00</b> | <b>(15,300,000.00)</b> |
| 2132   | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>                            | <b>15,300,000.00</b> | <b>(15,300,000.00)</b> |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                  | 15,300,000.00        | (15,300,000.00)        |
| 4      | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>  | <b>9,810,329.28</b>  | <b>(9,810,329.28)</b>  |
| 5      | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b> | <b>18,500,329.28</b> | <b>(18,500,329.28)</b> |

### **3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

---

Аудитаар нийт 213,317.9 мянган төгрөгийн 5 алдаа, 3 зөрчил илэрснээс 192,466.0 мянган төгрөгийн 5 алдааг аудитын явцад бүрэн залруулсан.

#### **3.1. Залруулсан алдаа**

1. Төсвийн гүйцэтгэлийн тайланд урсгал үйл ажиллагааны санхүүжилтийг 12,989.1 мянган төгрөгөөр дутуу, нэмэлт дансны үйл ажиллагааны орлогыг 23,990.0 мянган төгрөгөөр дутуу, мөнгөн гүйлгээний тайланд нийт зардлын дүнг 25,127.9 мянган төгрөгөөр илүү бүртгэсэн байсныг залруулсан.

2. Тайлант оны үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 119,393.6 мянган төгрөгөөр дутуу тооцоолсон байсныг үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайланд залруулсан.

3. Нэмэлт дансны үйл ажиллагааны орлого түрээсийн байрны 6,990.0 мянган төгрөгийг орлогоор бүртгээгүй байсныг орлогоор бүртгүүлж мөнгөн гүйлгээний тайланд залруулсан.

4. Сар дамнасан ээлжийн амралтын олговор 1,125.4 мянган төгрөгийг олгохдоо цалингийн авлага үүсгэлгүй шууд зардалд хаасан байсныг авлагаар тусгуулан залруулсан.

5. Төрийн албан хаагчийн түрээсийн байрны дутуу 2,850.0 мянган төгрөгийг авлага үүсгээгүй байсныг авлагаар бүртгүүлэн залруулсан.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 20,851.8 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан тул өөрчлөлттэй дүгнэлт өглөө.

#### **3.2. Албан шаардлага**

1. Тайлант онд Нийгмийн даатгалын шимтгэлийг шилжүүлэхдээ ажил олгогчоос шилжүүлэх 3,051.8 мянган төгрөгийг үндсэн цалингийн зардлаас шилжүүлэн зардлыг зориулалт бусаар зарцуулсан байна.

2. Нэмэлт санхүүжилтийн дансанд аж ахуйн нэгж, байгууллагаас нийгмийн хариуцлагын хүрээнд 17,800.0 мянган төгрөгийн мөнгөн хандив авч зарцуулсан байна.

#### **3.3. Зөвлөмж**

1. Эд хөрөнгийн тооллогыг албан хаагчдаар түүвэрлэн тоолж тулгалт хийхэд алба хаагчдад хөрөнгө ашиглалтын бүртгэл байхгүй, албан хаагчдын хэрэглэж байгаа хөрөнгөд хөрөнгө бүртгэлийн наалт байхгүй байгаа зэрэг нь тухайн албан хаагчийн хэрэглэж байгаа хөрөнгө мөн гэхийг нотлох боломжгүй байгаа бөгөөд, байгууллагын хагас жилийн тооллогыг албан хаагч бүрээр тулгаж тоолсон гэх нотолгоо хангалтгүй байсан зөрчилд зөвлөмж хүргүүлсэн.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга  | Нийт алдаа |                  | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан |                  | Буруу тусган илэрхийлсэн |     | Үүнээс     |                  |               |     | Зөвлөмж |     |
|--|------------|------------------|-----------------------------------|------------------|--------------------------|-----|------------|------------------|---------------|-----|---------|-----|
|  |            |                  |                                   |                  |                          |     | Залруулсан |                  | Залруул аагүй |     |         |     |
|  | Тоо        | Дүн              | Тоо                               | Дүн              | Тоо                      | Дүн | Тоо        | Дүн              | Тоо           | Дүн | Тоо     | Дүн |
| Орлого болон зардлыг илүү дутуу тусган илэрхийлсэн алдаа               | 1          | 62,107.0         | 1                                 | 62,107.0         |                          |     | 1          | 62,107.0         |               |     |         |     |
| Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал дутуу тооцоолсон                     | 1          | 119,393.6        | 1                                 | 119,393.6        |                          |     | 1          | 119,393.6        |               |     |         |     |
| Түрээсийн орлого бүртгээгүй орхисон                                    | 1          | 6,990.0          | 1                                 | 6,990.0          |                          |     | 1          | 6,990.0          |               |     |         |     |
| Ээлжийн амралтын тооцоог олгоходоо сар дамжсан мөнгийг авлаг тусгаагүй | 1          | 1,125.4          | 1                                 | 1,125.4          |                          |     | 1          | 1,125.4          |               |     |         |     |
| Түрээсийн дутуу төвлөрсөн дүнг авлага үүсгэх                           | 1          | 2,850.0          | 1                                 | 2,850.0          |                          |     | 1          | 2,850.0          |               |     |         |     |
| <b>Дүн</b>   | <b>5</b>   | <b>192,466.0</b> | <b>5</b>                          | <b>192,466.0</b> |                          |     | <b>5</b>   | <b>192,466.0</b> |               |     |         |     |

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга                                     | Нийт зөрчил |                 | Үүнээс        |     |                 |                 |          |          |                                      |             |   |     |  |
|--|-------------|-----------------|---------------|-----|-----------------|-----------------|----------|----------|--------------------------------------|-------------|---|-----|--|
|  |             |                 | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |                 | Зөвлөмж  |          | Хариуцлага тооцуулах албан шаардлага |             | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |     |  |
|  | Тоо         | Дүн             | Тоо           | Дүн | Тоо             | Дүн             | Тоо      | Дүн      | Тоо                                  | Албан тушаа | Тоо   | Дүн |  |
| Төсвийг зориулалт бусаар зарцуулсан                    | 1           | 3,051.8         |               |     | 1               | 3,051.8         |          |          |                                      |             |   |     |  |
| Хандивын мөнгөн хөрөнгийн зориулалт бусаар зарцуулсан. | 1           | 17,800.0        |               |     | 1               | 17,800.0        |          |          |                                      |             |   |     |  |
| Үндсэн хөрөнгийн тооллоготой холбоотой зөрчил          | 1           | -               |               |     |                 |                 | 1        | -        |                                      |             |   |     |  |
| <b>Дүн</b>   | <b>3</b>    | <b>20,851.8</b> |               |     | <b>2</b>        | <b>20,851.8</b> | <b>1</b> | <b>-</b> |                                      |             |   |     |  |

##### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга                                       | Нийт зөрчил |          | Үүнээс        |     |                 |     |          |          |
|--|-------------|----------|---------------|-----|-----------------|-----|----------|----------|
|  |             |          | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |     | Зөвлөмж  |          |
|  | Тоо         | Дүн      | Тоо           | Дүн | Тоо             | Дүн | Тоо      | Дүн      |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил |             |          |               |     |                 |     |          |          |
| Хуульд заасан мэдээллийг байршуулаагүй                   | 1           | -        |               |     |                 |     | 1        | -        |
| <b>Дүн</b>   | <b>1</b>    | <b>-</b> |               |     |                 |     | <b>1</b> | <b>-</b> |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил                 |             |          |               |     |                 |     |          |          |
| Дүн  |             |          |               |     |                 |     |          |          |
| Нийт дүн   | 1           |          |               |     |                 |     | 1        |          |